



## ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

**“ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА”-ЫН  
ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Улаанбаатар хот  
2020 он

## ГАРЧИГ

<b>УДИРТГАЛ .....</b>	<b>3</b>
<b>НЭГ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ .....</b>	<b>3</b>
Зорилгод хүрэх байдал .....	3
Практикт хэрэгжих боломж .....	3
Харилцан уялдаа .....	4
<b>ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ.....</b>	<b>4</b>
2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал .....	4
2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал .....	4
2.3. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.....	9
<b>ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ.....</b>	<b>9</b>
3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр хүрээнд хийсэн үнэлгээ: .....	9
3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ .....	12
3.3. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ .....	18
<b>ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ .....</b>	<b>Error! Bookmark not defined.</b>
4.1. Үнэлэлт, дүгнэлт .....	24
4.2. Зөвлөмж .....	26
<b>ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ .....</b>	<b>24</b>
Нэг. Хууль тогтоомж, олон улсын гэрээ, бусад эрх зүйн акт .....	24
Хоёр. Судалгаа, тайлан, төсөл, эмхэтгэл, ном, сэтгүүл .....	28

## **“ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

### **УДИРТГАЛ**

“Хууль тогтоомжийн тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6. дахь хэсэгт заасан аргачлалын дагуу Төмөр замын тээврийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулан батлуулсан. Тус үзэл баримтлалыг үндэслэн боловсруулсан “Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ын төсөлд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-ын дагуу үнэлэв.

“Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ын төслийг суурь судалгаанд тулгуурлан Төмөр замын тээврийн тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, уг төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах замаар төмөр замын тээврийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулах, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

Төмөр замын тээврийн тухай хуулийн төслийн /цаашид “Хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал” /цаашид “Аргачлал” гэх/-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

### **НЭГ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ**

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг тооцоходоо хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 3 шалгуур үзүүлэлт сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Харилцан уялдаа

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгоходоо дараах үндэслэлийг харгалзан үзсэн. Тухайлбал:

**Зорилгод хүрэх байдал:** Хуулийн төслийн зохицуулалтууд нь тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэж чадах эсэх; хуулийн төсөл боловсруулах үндэс шаардлагад нийцсэн эсэх; хуулийн төслөөр тавьсан зорилгод хүрч чадах эсэх;

**Практикт хэрэгжих боломж:** Хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэх; мөн хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх, ямар асуудал бэрхшээл учирч болох зэрэг нөхцөл байдлыг шалгах;

**Харилцан уялдаа:** Хуулийн төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хуультай нийцэж байгаа эсэх; хуулиар үүрэг хүлээсэн ч субъектүүдийн чиг үүрэг давхацсан эсхүл зөрчигдөж байгаа эсэхэд үнэлгээ хийх шаардлагатай гэж үзэж тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

## **ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ**

Энэхүү хэсэгт уг хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл заалтыг сонгоходоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий шинээр нэмж орж буй, голлох заалтыг сонгож, түүний үр нөлөөг судална.

Түүнчлэн хуулийн төсөл батлагдсанаар тодорхой зардал үүсгэж болохуйц, эсхүл гэрчилгээжүүлэлт, тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой, мөн тодорхой дэд бүтцийн өмчлөл, эзэмшил, үйлчилгээ, зураг төсөл болон ашиглалтын талаарх зохицуулалт, тээвэрлэлтийн үйл ажиллагааны төрөл, зориулалт, бодлого зохицуулалтыг тодорхойлон, төмөр замын төрийн болон тээвэрлэгч байгууллагад хүлээлгэх чиг үүрэг, мөн тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг тодорхой болгох шаардлагатай эсэх зэргийг харгалзан үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон.

Энэхүү тайлангийн нэгдүгээр хэсэгт сонгон авсан шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу авч үзье.

### **2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал**

“Төмөр замын тээврийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийн үндсэн зорилго нь Төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх, эзэмших, ашиглах, нэгдсэн зурмагаар зорчигч, ачаа тээвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршиж байна. Энэ зорилгод хүрэхийн тулд хуулийн төслөөр дараах зорилтуудыг сонгон дэвшүүлэн үнэлнэ. Тухайлбал,

Нэгдүгээр хүснэгт  
**Хуулийн төслийн зорилтуудыг сонгон үнэлэх**

<b>Зорилгод хүрэх байдал/ дагалдах зорилтууд</b>	<b>Сонгосон зүйл заалт</b>
Төмөр замын дэд бүтцийн өмчлөл, эзэмшил, ашиглалт	Хуулийн төслийн <b>26, 27</b> дугаар зүйл.
Хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх, эзэмших, ашиглах	Хуулийн төслийн <b>37</b> дугаар зүйл.
Нэгдсэн зурмагаар зорчигч, ачаа тээвэрлэхтэй холбоотой харилцаа	Хуулийн төслийн <b>40</b> дүгээр зүйл.

### **2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал**

Практикт хэрэгжих байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд 1/Төмөр замын дэд бүтцийн эзэмшигчийн эрх, үүрэгтэй холбоотой заалтууд, 2/Төмөр замын тээвэр дэх галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зохицуулалттай холбоотой заалтууд, 3/Төмөр замын дэд бүтцийн үйлчилгээ, ашиглалт зэрэг

зохицуулалтыг сонгон авч “Практикт хэрэгжих байдал”-ын үр нөлөөг нь тооцсон болно. Сонгосон зүйл заалтуудыг дэлгэрэнгүйг хүснэгтээр үзүүлэв.

Хоёрдугаар хүснэгт  
**Хуулийн төслийн зорилтуудыг сонгон үнэлэх**

Д/д	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл заалт
1	Төмөр замын дэд бүтцийн эзэмшигчийн эрх, үүрэгтэй холбоотой заалтууд	<p><b>27 дугаар зүйл. Төмөр замын дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүрэг:</b></p> <p>27.1.1 төмөр замын дэд бүтцийг гэрээний үндсэн дээр тээвэрлэгч, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчид ашиглуулах;</p> <p>27.1.2 төмөр замын дэд бүтэц ашиглуулсны төлбөр, засвар, үйлчилгээний хөлс авах;</p> <p>27.1.3 тээвэрлэгчийн тээвэрлэлтийн ажлын технологи, хөдлөх бүрэлдэхүүний техникийн үзүүлэлт, хүчин чадал нь төмөр замын дэд бүтцийн нэвтрүүлэх чадварыг бүрэн ашиглахад сөргөөр нөлөөлөхүйц байвал тээвэрлэгчээс татгалзах;</p> <p>27.1.4 тээвэрлэлтэд оролцож байгаа хөдлөх бүрэлдэхүүний засвар хоорондын хугацаа, техникийн байдалд хяналт тавьж, зөрчлийг арилгуулахыг шаардах, шаардлагатай тохиолдолд дэд бүтэц ашиглуулахаас татгалзах;</p> <p>27.1.5 аюултай ачааны тээвэрлэлт болон хүнд жинтэй, хэтрүү овортой зэрэг онцгой нөхцөл шаардсан галт тэргэнд тээвэрлэгчийн зүгээс хяналт тавьж тээвэрлэлтийн явцад аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авахыг шаардах;</p> <p>27.1.6 холбогдох хууль тогтоомж, <b>төмөр замын тээврийн дүрэм, журам</b>, техникийн зохицуулалт, стандарт, норм нормативын баримт бичгийн шаардлагад нийцээгүй хөдлөх бүрэлдэхүүнийг өөрийн дэд бүтцэд нэвтрүүлэхгүй байх;</p> <p>27.1.7 хууль тогтоомжид заасан бусад эрх.</p> <p><b>27.2 Төмөр замын дэд бүтэц эзэмшигч нь дараах үүрэгтэй:</b></p> <p>27.2.1 төмөр замын дэд бүтэц ашиглуулах үйлчилгээний тариф хэрэглэх дүрмийг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу энэ хууль болон Орсөлдөөний тухай хуульд нийцүүлэн тогтоох;</p>

	<p>27.2.2 төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, техникийн зохицуулалт, дүрэм, журам, стандарт, холбогдох бусад эрх зүйн актыг дагаж мөрдөх;</p> <p>27.2.3 хөдөлгөөний нэгдсэн зурмаг болон дэд бүтэц дэх хөдөлгөөний зурмагийг биелүүлж, өөрийн дэд бүтцийн хүрээнд галт тэрэгний хөдөлгөөнийг зохион байгуулах;</p> <p>27.2.4 холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, техникийн зохицуулалт, стандартын шаардлагад нийцээгүй хөдлөх бүрэлдэхүүнийг өөрийн дэд бүтцэд нэвтрүүлэхгүй байх;</p> <p>27.2.5 өөрийн дэд бүтэцтэй холбогдсон төмөр замын дэд бүтэц, салбар зам эзэмшигчтэй гэрээ байгуулж, галт тэрэгний хөдөлгөөнийг зохион байгуулах;</p> <p>27.2.6 Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу өөрийн дэд бүтэц дэх хөдөлгөөний зурмагийг боловсруулж, батлах;</p> <p>27.2.7 галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагт санал өгөх;</p> <p>27.2.8 эзэмшиж, ашиглаж байгаа хатуу тооцоот багаж хэрэгслийг Тагнуулын ерөнхий газарт бүртгүүлэх;</p> <p>27.2.9 тусгай зөвшөөрөл, аюулгүй байдлын гэрчилгээтэй байх;</p> <p>27.2.10 шаардлагатай мэргэжлийн ажилтантай байх;</p> <p>27.2.11 эзэмшиж байгаа төмөр замын дэд бүтцийн тасралтгүй, хэвийн, аюулгүй ажиллагааг хангах;</p> <p>27.2.12 тогтоосон журам, технологийн дагуу дэд бүтцийг засварлах, арчлах;</p> <p>27.2.13 дүрэм, журмын дагуу эрх бүхий байгууллагад холбогдох мэдээ, тайлан гаргах;</p> <p>27.2.14 хууль тогтоомжид заасан бусад үүрэг.</p>
	<p><b>48 дугаар зүйл. Төмөр замын тээвэр дэх галт тэрэгний хөдөлгөөний удирдлага, зохицуулалт</b></p> <p>48.1 Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа хоногийн 24 цагийн туршид тасралтгүй явагдана.</p> <p>48.2 Галт тэрэгний хөдөлгөөнийг техникийн нормчлолын дагуу зохиосон зурмагаар зохицуулна.</p>

2	<p>Төмөр замын тээвэр дэх галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зохицуулалттай холбоотой заалтууд</p>	<p><b>48.3 Техникийн нормчлолыг дор дурдсанаар боловсруулж мөрдөнө:</b></p> <p>48.3.1 Төмөр замын дэд бүтэц нь өөрийн дэд бүтцийн жилийн техникийн нормчлолыг боловсруулан баталж, тухай бүр тодотгож мөрдөнө.</p> <p>Төмөр замын дэд бүтцүүдийн техникийн нормчлолд үндэслэн <b>Төмөр замын тээврийн нэгдсэн удирдлага, зохицуулалтын асуудал хариуцсан байгууллага</b> тухайн жилийн улсын нэгдсэн техникийн нормчлолыг боловсруулан баталж, тухай бүр тодотгоно.</p> <p>48.3.2 Төмөр замын дэд бүтэц нь галт тэрэгний хөдөлгөөн удирдах диспетчерийн төвтэй байна.</p> <p>48.3.3 Төмөр замын тээврийн нэгдсэн <b>удирдлага, зохицуулалтын асуудал хариуцсан байгууллага</b> төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу төмөр замын дэд бүтэц хоорондын үйл ажиллагааны уялдааг хангаж, улсын хэмжээнд галт тэрэгний хөдөлгөөнийг нэгдсэн зурмагаар зохицуулна.</p> <p>48.3.4 Төмөр замын дэд бүтэц эзэмшигч нь хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн өөрийн нэвтрүүлэх чадварыг тооцоолж, оновчтой ашиглах үүрэгтэй.</p> <p>48.3.5 Төмөр замын дэд бүтцийн галт тэрэгний хөдөлгөөний зурмагийг боловсронгуй болгох саналыг төрийн болон орон нутгийн байгууллага, тээвэрлэгч, тээвэр зуучлагч, зорчигч, ачаа илгээгч, хүлээн авагч, иргэд гаргах эрхтэй.</p> <p>48.3.6 Төмөр замын дэд бүтэц эзэмшигч саналыг хүлээж авсан өдрөөс 30 хоногийн дотор тухайн саналыг авч үзэн, хэрхэн шийдвэрлэсэн талаар санал гаргагчид хариу мэдэгдэх үүрэгтэй.</p> <p><b>48.4 Санал гаргагч нь энэ тухай төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гомдол гаргах эрхтэй.</b></p> <p><b>48.5 Төрийн бус байгууллага, иргэн нь галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах ажлыг saatuuлах, төмөр замын тээврийн тасралтгүй үйл ажиллагааг зогсоохыг хориглоно.</b></p>
3	<p>Төмөр замын дэд бүтцийн үйлчилгээ</p>	<p><b>28 дугаар зүйл. Төмөр замын дэд бүтцийн үйлчилгээ</b></p> <p>28.1. Төмөр замын дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь өмчийн хэлбэрээс үл хамааран тээвэрлэгч, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн оператор болон бусад этгээдэд тусгай зөвшөөрлийн үндсэн дээр дэд бүтцийн үйлчилгээ үзүүлнэ.</p>

	<p>28.2 Төмөр замын дэд бүтцийн үйлчилгээ нь төмөр замын тээврийн аюулгүй байдал, техникийн зохицуулалт, стандартын шаардлагад нийцсэн байна.</p> <p>28.3 Төмөр замын дэд бүтцийн үйлчилгээг тэгш эрхийн зарчмыг баримтлан, гэрээний үндсэн дээр үзүүлнэ.</p> <p>28.4 Төмөр замын дэд бүтэц өмчлөгч, эзэмшигч нь тухайн дэд бүтцийн өргөтгөл, шинэчлэлт сайжруулалтын суурь судалгаа бүхий хөгжлийн өрөнхий төлөвлөгөөтэй байх ба төлөвлөгөө нь төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлоготой уялдсан байна.</p> <p>28.5. Төмөр замын дэд бүтцийн үйлчилгээ нь үндсэн болон нэмэлт үйлчилгээнээс бүрдэнэ.</p> <p>28.6. Төмөр замын дэд бүтцийн үндсэн үйлчилгээнд дараах үйлчилгээ хамаарна:</p> <p>28.6.1. галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн хуваарь ашиглуулах;</p> <p>28.6.2. галт тэрэгний хөдөлгөөнд зам, суман шилжүүлэг ашиглуулах;</p> <p>28.6.3. галт тэрэгний хөдөлгөөнийг харилцаа холбоо, дохиоллын систем ашиглан зохион байгуулах, диспетчерийн удирдлага, түүнчлэн галт тэрэгний хөдөлгөөнтэй холбоотой мэдээлэл солилцох, дамжуулах, тээвэрлэгч, тээвэрлүүлэгчид тээвэрлэлтийн үйлчилгээтэй холбоотой мэдээллээр хангах;</p> <p>28.6.4. төмөр замын зурvas газар, аюултай, аюулгүйн бүсэд төмөр замын үйлдвэрлэл, үйлчилгээ <b>үзүүлэх</b></p> <p>28.6.5. аюултай, хэтрүү овортой, хамгаалалттай ачаатай хөдлөх бүрэлдэхүүн, хүнд жинтэй, урт бүрэлдэхүүнтэй галт тэргэнд тавих хяналт;</p> <p>28.6.6. онцгой нөхцөл шаардсан тусгай тээвэрлэлт;</p> <p>28.6.7. зорчигчийн вагоны зэхэлт;</p> <p>28.6.8. зорчигчидод үйлчлэх үйлчилгээний стандартыг мөрдөх;</p> <p>28.6.9. галт тэргийг найруулах, сэлгээний ажил;</p> <p>28.6.10. хөдлөх бүрэлдэхүүний сэлбэг хэрэгсэлийн хангамж.</p> <p>28.7. Төмөр замын дэд бүтцийн нэмэлт үйлчилгээнд дараах үйлчилгээ хамаарна:</p>
--	---

		<p>28.7.1. хөдлөх бүрэлдэхүүнийг эрчим хүчээр хангах, түлш, шатахуун, ус, хийн хангамж;</p> <p>28.7.2 хөдлөх бүрэлдэхүүнд хийх техникийн үзлэг, оношилгоо, магадлагаа;</p> <p>28.7.3. төмөр замын тээврийн үйлчилгээ, ашиглалттай холбоотой харилцаа холбоо, мэдээлэл, сүлжээ, програм хангамж.</p> <p>28.8. Төмөр замын дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэх журмыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.</p>
--	--	--

### **2.3. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийс үр нөлөөг нь тооцох хэсээг тогтоосон байдал**

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно. /Хуулийн төсөл нь 11 бүлэг, 78 зүйлтэй/

### **ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

Энэхүү тайлангийн Хуулийн төслийн 2,3,4,5,6,7 дугаар бүлгүүдээс сонгосон зүйлүүдийн шалгуур үзүүлэлтуүдийн хүрээнд дараах байдлаар үнэлгээ хийлээ.

Гуравдугаар хүснэгт  
**Хуулийн төслийн сонгон авсан бүлэг, зүйлийг үнэлэх**

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 11,15, 22, 38, 42 дугаар зүйл	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 13, 16, 22, 25 дугаар зүйл	Практикт туршилт хийх, практикт тухайн төрлийн харилцаа, гарч болох хүндрэлийг судлах.
3	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь тооцно	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгуудаар шалгах

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ:

#### **3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр хүрээнд хийсэн үнэлгээ**

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зорилгыг аргачлалын дагуу төсөлд тусгагдсан зохицуулалт, арга хэмжээнүүд нь тавьсан зорилгод хүрэх боломжтой эсэхийг үнэлэх болно.

Дөрөвдүгээр хүснэгт

**Хуулийн төслийн зорилго нь төслийн зохицуулалт, арга хэмжээнүүдэд  
хүрэх боломжтой эсэхийг үнэлэх**

Төмөр замын тээврийн тухай хуулийн зорилгын хүрээнд хуулийн төслийн 16, 18, 33, 42, 55 дахь заалтад дүн шинжилгээ хийсэн байдал.

Хуулийн нэгдүгээр зүйлд “Энэхүү хуулийн зорилго нь төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх, эзэмших, ашиглах, нэгдсэн зурмагаар зорчигч, ачаа тээвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино” хэмээн ерөнхий зорилтыг тодорхойлж өгсөн байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэх үүднээс хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төмөр замын дэд бүтэц дараах бүрдэл хэсэгтэй байна” гэж төмөр замын дэд бүтцийг 9-н бүрдэлтэй байхаар хуульчилсан. Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нийтийн хэрэгцээний төмөр замын дэд бүтэц төрийн өмчид байх бөгөөд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд эзэмшинэ”, 18.2-д “Нийтийн бус хэрэгцээний төмөр замын дэд бүтэц төрийн болон хувийн өмчийн аль ч хэлбэрийн байж болно”, 18.3-д Төмөр замын дэд бүтцийг концессын барих-ашиглах-шилжүүлэх төрлөөр барьж байгуулсан бол уг гэрээний хугацаанд концесс эзэмшигч нь тухайн дэд бүтцийн эзэмшигч байна” гэж хуулийн төсөлд тус тус тусгаж хуулийн зорилгод нийцүүлсэн байна.

Тавдугаар хүснэгт

**Хуулийн төслийн 35 дугаар зүйлийг үнэлэх**

**35 дугаар зүйл. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгт тавигдах шаардлага**

35.1. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг нь ялгах өнгө, тэмдэг, үйлдвэрлэгч, өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн мэдээллийг агуулсан бичвэртэй байх бөгөөд тэдгээр нь стандартын шаардлага хангасан байна.

35.2. Хөдлөх бүрэлдэхүүнийг улсын бүртгэлд бүртгүүлж, дугаар, гэрчилгээ авсан байна.

35.3. Чингэлгийг улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

35.4. Монгол Улсын нутаг дэвсгэрт хөдлөх бүрэлдэхүүний өмчлөл, эзэмшил өөрчлөгдсөн тохиолдолд Төмөр замын тээврийн хөдөлгөөний нэгдсэн удирдлага, зохицуулалтын асуудал эрхэлсэн байгууллагад мэдэгдэж, бүртгэлийг шинэчилнэ.

35.5. Хөдлөх бүрэлдэхүүний паркийг бүрдүүлэхэд эдийн засгийн үр ашигтай байх, засвар, ашиглалтын технологийн нийцлийг хангасан байх зарчмыг баримтална.

35.6. Хөдлөх бүрэлдэхүүнийг улсын бүртгэлд дараах тохиолдолд бүртгэхгүй:

35.6.1. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын шаардлага хангаагүй;

35.6.2. холбогдох хууль тогтоомжийн дагуу баримт бичгийн бүрдүүлэлт хийгээгүй;

35.6.3. үйлдвэрлэгч, ашиглагч улсад төмөр замын тээвэрт явуулахыг хориглосон, улсын бүртгэлээс хассан;

35.6.4. ашиглалтын хугацаа нь олон улсын гэрээ, төмөр замын дүрэм, журам, стандартад заасан шаардлагад нийцээгүй;

35.6.5. техникийн үзүүлэлт нь техникийн баримт бичигтэй зөрсөн, хуурамчаар үйлдсэн болох нь нотлогдсон.

35.7. Энэ хуулийн 35.6-д заасан улсын бүртгэлд бүртгүүлээгүй болон ашиглалтын хугацаа дууссан хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг төмөр замын тээвэрлэлтэд ашиглахыг хориглоно.

35.8. Хөдлөх бүрэлдэхүүний техникийн үзүүлэлт, оношилгоо, засвар, ашиглалтын талаарх техникийн хяналтын ажлыг төмөр замын тээврийн нэгдсэн хөдөлгөөн удирдлага, зохицуулалтын асуудал эрхэлсэн байгууллага зохион байгуулна.

### **37 дугаар зүйл. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн ашиглалт**

37.1. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн ашиглалт, засвар үйлчилгээ тэдгээрийн төлбөр, тооцоотой холбоотой харилцааг энэ хуулийн 12.3.11-т заасан журмаар зохицуулна.

37.2 Тээвэрлэгч, ачаа илгээгч, хүлээн авагч, тээвэр зуучлагч нь бусдын эзэмшлийн хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр тээвэрт ашиглах, ачилтад авахыг хориглоно.

37.3 Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн хийцийн тогтоосон даацыг хэтрүүлэх болон өөрчлөхийг хориглоно.

Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн бүртгэлийн үйл ажиллагааг Төмөр замын тээврийн нэгдсэн удирдлага, зохицуулалтын асуудал хариуцсан байгууллага улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулахаар тусгаж, Улсын бүртгэлд хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийг бүртгэх, Төмөр замын тээврийн нэгдсэн удирдлага, зохицуулалтын асуудал хариуцсан байгууллагад ажилд Төрийн бус байгууллага, иргэн нь саатуулах төмөр замын тээврийн тасралтгүй үйл ажиллагааг зогсоохыг хориглосон зохицуулалтыг тусгажээ.

Зургадугаар хүснэгт

### **Хуулийн төслийн 40 дугаар зүйлийг үнэлэх**

#### **40 дүгээр зүйл. Зорчигч, ачаа тээвэрлэлтэд тавигдах шаардлага**

40.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт төмөр замаар зорчигч, ачаа тээвэрлэхдээ энэ хууль болон төмөр замын тээврийн дүрэм, журмаар зохицуулна.

40.2. Төмөр замын тээвэрлэлтийн гэрээ нь төмөр замын байгууллага болон зорчигч, ачаа илгээгч, ачаа хүлээн авагч хоорондын харилцааг зохицуулна.

40.3. Зорчигчийн зорчих тасалбар, тээш, ачаан тээшийн тасалбар, тээвэрлэлтийн падаан нь тээврийн гэрээ буюу түүний бүрэлдэхүүн хэсэг болно.

40.4. Төмөр замаар зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх харилцааг энэ хуулийн 12.2.4-т заасан дүрмээр зохицуулна.

40.5. Зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэлтэд дараах шаардлага тавигдана:

40.5.1. тээвэрлэгч нь зорчигчийг гэрээнд заасан галт тэргэнд зорчих тасалбарт заасан суудлаар хангах, тээш, ачаан тээшийг хүрэх газарт нь хүргэх;

40.5.2. тээвэрлэгч нь зорчигч, тээш, ачаан тээшийг хүлээн авч, гэрээнд заасан өртөө хүртэл аюулгүй, бүрэн бүтэн байдлыг ханган тээвэрлэх;

40.5.3. тээш, ачаан тээш нь стандартад заагдсан хэмжээ, сав, баглаа боодолтой байх.

40.6. Төмөр замаар ачааг тээвэрлэх харилцааг энэ хуулийн 12.1.3-т заасан дүрмээр зохицуулна.

40.7. Тээвэрлэгч нь тээвэрлэлтийг гүйцэтгэхдээ ачаа илгээгч, ачаа хүлээн авагчийн ачаа, тээш, ачаан тээшийг үрэгдүүлсэн, дутаасан, гэмтээсэн, муутгасан болон ачаа хүргэх хугацааг хожимдуулсан хариуцлагыг тээврийн гэрээнд заасан дагуу барагдуулна.

40.8. Төмөр замын тусгай тээвэрлэлт, төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх харилцааг төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмаар зохицуулна.

40.9. Тээвэрлэлтийн явцад тээвэрлэгчийн буруугаар бусдын амь нас, эрүүл мэндэд гэм хор учирсан тохиолдолд Иргэний хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

Хуулийн төслийн 40 дугаар зүйлд зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээ үүсэх үндэслэл, нотлох баримт бичиг, зорчигчийн болон тээвэрлэгчийн үүргийн талаар тусгаж, зорчигчийн эрх үүргийг хуулийн төслийн 45 дугаар зүйлд тээш, ачаан тээш тээвэрлэлтийн талаар тус тус давхардуулан тусгасан байсан.

Хуулийн төслийн 42 дугаар зүйлд ачаа тээвэрлэлтийн төлөвлөлт, тээвэрлэлтийн гэрээ, ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах гэрээний үндсэн дээр гүйцэтгэх үйл ажиллагаа, мөн гэрээг илгээгчээс өгөгдсөн тээвэрлэлтийн захиалгад үндэслэн зохион байгуулах, захиалгын маягтыг бүрдүүлэх, бөглөх, өөрчлөлт оруулах, бүртгэх журам, ачаа тээвэрлэх дүрэм зэргийг тогтоож, Олон улсын харилцаанд ачаа тээвэрлэх захиалга өгөх ажиллагааг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний дагуу гүйцэтгэхээр тусгасан байна.

Ерөнхий зорилгоос үзэхэд Төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх, эзэмших, ашиглах, нэгдсэн зурмагаар зорчигч, ачаа тээвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулахаар хуулийн төсөлд тусгасан боловч Төмөр замын тээврийн зориулалттай газар, төмөр замын тээврийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл гэрчилгээжүүлэлт, төмөр замын ачаа, зорчигч болон тусгай тээвэрлэлт, төмөр замын тээврийн салбар дахь эдийн засаг санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалт, төмөр замын тээврийн аюулгүй байдал, төмөр замын тээврийн салбарын ажилтны хөдөлмөрийн харилцааны онцлог зохицуулалт, төмөр замын тээврийн салбарын бусад үйл ажиллагааг зохицуулахаар боловсруулсан байна.

### **3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ**

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хуульчилж байгаа зохицуулалт нь дагаж мөрдөж, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг үнэлэх болно.

Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг тооцохдоо хуулийн төслийг хэрэгжүүлэгч мэргэжлийн байгууллага, төмөр замын тээврийн төр, хувийн хэвшлийн байгууллага, тээвэрт оролцогч, эрх нь хөндөгдөх этгээд, судлаач нараас төсөлд санал авах, Төмөр замын тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлан, албан ёсны цахим хуудасны мэдээлэл, Монгол Улсын хилээр хөдлөх бүрэлдэхүүнийг нэвтрүүлэх, бүртгэх үйл ажиллагаанд дун шинжилгээ хийх замаар шалгасан.

Эдгээрийг практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн заалтуудыг сонгон судлах болно. Дээрх заалтуудын практикт хэрэгжих боломжийг судлахдаа Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч, дэд бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигчийн эрх үүрэг, үйл ажиллагааг жишиг болгон авч үзсэн. Практикт хэрэгжих боломжийг дараах асуултад хариулахыг эрмэлзлээ. Үүнд:

1. Хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект байгаа эсэх
2. Хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд боломж бололцоо байгаа эсэх

### Хуулийн төслийн 15, 26, 28, 32, 38 дугаар зүйлийг үнэлэх

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зорилгын хүрээнд Төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх, эзэмших, ашиглах зорилгын хүрээнд хуулийн төслийн **15, 26, 28, 32, 38** дугаар зүйлд дүн шинжилгээ хийсэн байдал.

#### 3.2.1 Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх:

Төмөр замын тээврийн тухай хуулийг хэрэгжүүлэх үүрэг бүхий субъект болох Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын талаар Хуулийн төслийн 9 дүгээр зүйлд төмөр замын тээврийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төмөр замын тээврийн, хөдөлгөөний, хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлчилгээний чанар хүртээмж, эрүүл ахуй болон экологийн төрийн хяналтыг хэрэгжүүлэх зэрэг эрх, үүрэгтэй байхаар тусгажээ.

Мөн төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх, эзэмших, ашиглах зорилтыг хэрэгжүүлэх субъектын нэг болох Төмөр замын тээврийн нэгдсэн удирдлага, зохицуулалтын асуудал хариуцсан байгууллагын чиг үүргийг Хуулийн төслийн 11 дугаар зүйлд ерөнхийд нь “төмөр замын дэд бүтэц хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг нэгдсэн зохицуулалтаар хангах, хөдөлгөөний нэгдсэн зурмагийг баталж, дэд бүтэц хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг оновчтой зохицуулах, дэд бүтцийн тээх, нэвтрүүлэх чадвар, хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтад дүн шинжилгээ хийж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, дэд бүтэц эзэмшигчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, төмөр замын тээврийн хүртээмжтэй байдлыг хянах, тээвэрлэлтийн статистикийн тайлан мэдээг төмөр замын байгууллагаас авч, нэгтгэх, мөн тээвэрлэгч, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн оператор, тээвэр зуучийн тэгш оролцоог хангуулах үүргийг хангах чиг үүрэг”-тэй байхаар хуульчилсан байна.

Энэхүү чиг үүрэг нь дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн эзэмших, ашиглагчийн тээвэрлэлт болон галт тэрэгний хөдөлгөөнийг нэгдмэл байдлаар зохицуулах, төмөр замын тээвэрлэлтийн статистик тайлан мэдээг бүрдүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлсон байна.

Хуулийн төслийн 28 дугаар зүйлд “Төмөр замын дэд бүтцийн үйлчилгээ”-ний талаар “дэд бүтцийн өмчлөгч, эзэмшигч нь өмчийн хэлбэрээс үл хамааран тээвэрлэгч, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн оператор нь гэрээний үндсэн дээр дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэх” зохицуулалтыг тусгасан байна. Мөн дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэх, ажил, үйлчилгээ гүйцэтгэх, дэд бүтцийг тэгш эрхийн зарчмыг баримтлан, тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашиглуулахтай холбоотой харилцааг зохицуулахаар тусгасан байна.

Хуулийн төслийн 26 дугаар зүйлд Төмөр замын дэд бүтцийн эзэмшигч нь гэрээний үндсэн дээр тээвэрлэгч, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчид дэд бүтэц ашиглуулсны төлбөр, засвар, үйлчилгээний хөлс авч ашиглуулахдаа батлагдсан аргачлал, холбогдох хууль, дүрэм, журам, стандарт бусад эрх зүйн актын дагуу өөрийн дэд бүтцийн хүрээнд галт тэрэгний хөдөлгөөний зохион байгуулах, төмөр замын дэд бүтцийн тасралтгүй, хэвийн, аюулгүй ажиллагааг хангах, тогтоосон журам, технологийн дагуу дэд бүтцийг засварлах, арчлах, ашиглахад сергөөр нөлөөлөхүйц байвал тээвэрлэгчээс татгалзах зэрэг эрх, үүргийг хэрэгжүүлэхээр тусгажээ.

#### 3.2.2 Төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд боломж бололцоо байгаа эсэх

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд “Төмөр замын тээврийн нэгдсэн удирдлага, зохицуулалтын асуудал хариуцсан байгууллагын чиг үүргийг “Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийг батлаж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахын тулд дэд бүтцийг оновчтой зохицуулж, түүний тээх,

нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэн, хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөнийг зохицуулж дугаар олгох, бүртгэх, ашиглалтын байдалд дүн шинжилгээ хийх” гэж тусгасан нь Төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх, эзэмших, ашиглах боломжийг бүрдүүлжээ.

Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийг байгуулж, үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны дүрмийг батлан, хуульчилсан.

Наймдугаар хүснэгт

**Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийг Төмөр замын тээврийн нэгдсэн удирдлага, зохицуулалтын асуудал эрхэлсэн байгууллага”-ын гүйцэтгэх чиг үүргийн харьцуулан үнэлэх**

<b>Д/д</b>	<b>Одоо дагаж мөрдөж байгаа хуулийн заалт</b>	<b>Хуулийн төслийн заалт</b>
<b>Чиг үүрэг, бүрэн эрх</b>		
Тээврийн нэгдсэн удирдлагын хэлтэс	14.1.Галт тэрэгний төв нь төмөр замын байгууллагуудын галт тэрэгний хөдөлгөөнийг уялдуулан зохицуулах чиг үүрэгтэй.	11.2.1. төмөр замуудын галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийг боловсруулах, батлах, гүйцэтгэлд хяналт тавих, шинжилгээ хийх;
	14.2.Хөдөлгөөн зохицуулалтын төвийн ажиллах журмыг төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмээр тодорхойлно.	11.2.2. төмөр замын дэд бүтэц эзэмшигч хооронд ачаа солилцох гэрээг бүртгэх, технологийн нэгдмэл бодлогоор хангах;
	14.3.1.хөдөлгөөний нэгдсэн зурмагийг батлах;	11.2.3. төмөр замын зангилаа өртөөдийн нэгдсэн технологийн горимыг баталж, техникийн норматив биелэлтэд хяналт тавих;
	14.3.2.хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд суурь бүтцүүдийн хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг захирамжлан зохион байгуулах	11.2.4. төмөр замын тээврийн статистик тайлан, мэдээг улсын хэмжээнд нэгтгэх, дүн шинжилгээ хийх, эрх бүхий байгуулагад мэдээлэх;
Гэрчилгээхүүлэлт хөдлөх бүрэлдэхүүний хэлтэс	14.3.3.суурь бүтэц эзэмшигч хоорондын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын харилцан уялдааг хангах;	11.2.5. төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосны дагуу олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудтай хамтран ажиллах, хилийн төмөр замуудын зөвлөгөөнд оролцох, санал, зөвлөмжийг дэвшүүлэх;
	14.3.4.галт тэрэгний хөдөлгөөний удирдлагатай холбоотой санал, дүгнэлт гаргаж шийдвэрлүүлэх;	11.2.6. хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, дугаар, гэрчилгээ олгох, баталгаажуулах;
	14.3.5.галт тэрэгний хөдөлгөөний удирдлагыг хэрэгжүүлэхэд чиглэсэн суурь бүтэц эзэмшигчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;	11.2.7. төмөр замын тээврийн зарим бүтээгдэхүүн, үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, гэрчилгээ, тохирлын үнэлгээ, баталгаажуулалтыг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох талаар эрх бүхий байгууллагад санал оруулах;
	14.3.6.тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч төмөр замын байгууллагын нэгдсэн технологийн горимыг боловсруулах;	11.2.8. төмөр замын тээвэрлэлтийн талаар иргэд байгууллагын гомдлыг хүлээн авах шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;
	14.3.7.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.	11.2.9 холбогдох хууль тогтоомжид заасны дагуу төмөр замын дэд бүтцийн дохиолол холбоо, сүлжээний радио зурсасыг ашиглах, хуваарилах;
		11.2.10. төмөр замын мэргэжлийн ажилтныг давтан сургах, мэргшүүлэх, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох ажлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах;
		11.2.11. төмөр замын тээвэрт гарсан сүйрэл, осол, <b>аюулгүй байдал алдагдсан</b> шалтгааныг шинжлэн судалж, шинжээчийн дүгнэлт гаргах, арга хэмжээ авах;

	11.2.12. төмөр замын салбарын эрдэм шинжилгээ, судалгаа, шинжлэх ухаан технологийн бодлогыг хэрэгжүүлэх;
	11.2.13. Төмөр замын дэд бүтэц, салбар замын хувийн хэрэг хөтлөх, төмөр замын тээврийн салбарын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх.

Төмөр замын тээврийн тухай 2007 оны хуулийн 12 зүйлд “Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага түүний бүрэн эрх”-ийн талаар зохицуулсныг 2012 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр хүчингүй болгосон. Энэхүү Төрийн захиргааны байгууллагыг дахин шинээр байгуулахаар хуулийн төслийн 9 дүгээр зүйлд дараах байдлаар тусгасан байна.

Есдүгээр хүснэгт

### Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийг үнэлэх

#### 9 дүгээр зүйл. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

1.1. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

1.1.1. төмөр замын тээврийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих;

1.1.2. хуулиар олгосон бүрэн эрхийнхээ хүрээнд дүрэм, журам баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

1.1.3. төмөр замын тээврийн салбарт шударга бус өрсөлдөөн үүсэхээс сэргийлэх зорилгоор тариф хэрэглэх дүрмийг хянаж, санал, дүгнэлт гаргах;

1.1.4. төмөр замын тээврийн аюулгүй байдал, үйлчилгээний чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төрийн хяналтыг хэрэгжүүлэх;

1.1.5. төмөр замын салбарын мэдээллийг цуглуулах, нэгтгэх, бүртгэх дүгнэлт гаргах, дүн шинжилгээ хийх;

1.1.6. төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосны дагуу төмөр замын олон улсын хамтын ажиллагаанд Монгол Улсыг төлөөлөх;

1.1.7. төмөр замын тээврийн салбарт мөрдөх улсын стандартыг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах;

1.1.8. төмөр замын хамтын ажиллагааны байгууллагын баталсан дүрэм, журмыг Монгол Улсын төмөр замын тээвэрт мөрдүүлэх ажлыг зохион байгуулах;

1.1.9. төмөр замын дэд бүтцийн болон тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийн харилцан мэдээлэл солилцох журмыг батлах;

1.1.10. хатуу тооцоот багаж, хэрэгслийн төрөл, үйлдвэрлэх, худалдах, ашиглах болон хүлээлцэх журмыг батлах;

1.1.11. хуульд заасан бусад бүрэн эрх.

**Хуулийн төслийн 28 дугаар зүйлд:** “Төмөр замын дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь өмчийн хэлбэрээс үл хамааран тээвэрлэгч, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн оператор болон бусад этгээдэд тусгай зөвшөөрлийн үндсэн дээр дэд бүтцийн үйлчилгээ үзүүлнэ. Дэд бүтцийн үйлчилгээ нь тэгш эрхийн зарчмыг баримтлан, гэрээний үндэслэн, төмөр замын тээврийн аюулгүй байдал, техникийн зохицуулалт, стандартын шаардлагад нийцүүлсэн байна.” гэж хуульчилсан.

Төмөр замын тээврийн салбарт 2019 оны 01 дүгээр сарын байдлаар нийт 184 зүтгүүр, 342 зорчигчийн вагон, 7528 ачааны вагон, 407 машин механизм нийт 8461 хөдлөх бүрэлдэхүүнээр тээвэрлэлтийн ажил, үйлчилгээ гүйцэтгэж байна.

Төмөр замын тээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан зохицуулалтын дагуу 2007 онд үндэсний 8 стандарт, 2013 онд үндэсний 21 стандартыг мөрдөж байсан бол 2012 оноос евростандартыг нэвтрүүлэх зорилтот төслийг хэрэгжүүлснээр 2018 оны 08 дугаар сарын 06-ний байдлаар Стандартын улсын үзлэгээр төмөр замын тээврийн салбарын Үндэсний 154 стандартын MNS-45, MNS EN-93, MNSGOST-R-2, MNSTB-1 нийт 6825 нүүр техникийн зохицуулалтын баримт бичиг хэрэглэгдэж байна.

Хуулийн төсөл батлагдснаар төмөр замын дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь өмчийн төрөл хэлбэрээс үл хамааран тээвэрлэгч, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн оператор болон бусад этгээдэдийн харилцааг зохицуулах боломжтой болно.

Улсын хэмжээнд 2007 онд 2800 хөдлөх бүрэлдэхүүнтэй, 14,1 сая тн ачаа хоногийн дундаж ачаалал 494 вагон, нэг голд ноогдох, статик даац 51.1тн, ачаа тээвэрлээт 14072.6, ОХУ-65327 вагон, БНХАУ-31126 вагон, зорчигч эргэлт 4410.7, зорчигч тээвэрлэлт 1406 сая зорчигч байв. 2018 онд 8403 хөдлөх бүрэлдэхүүнтэй болж, 25.1 сая тн ачаа, 2565890 зорчигч тээвэрлэсэн байсан.

Хуулийн төслийн 22 дугаар зүйлд “Төмөр замын дэд бүтэц эзэмшигчийн эрх, үүргийг хуульчилсан нь төмөр замын дэд бүтцийг эзэмших нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Уул уурхай, барилга, бусад салбарын хөгжил эрчимжсэнээр төмөр замын тээврийн эрэлт хэрэгцээ нэмэгдэж төмөр замын тээврийн салбарт өмчийн олон хэлбэрийн хуулийн этгээдүүд олноор байгуулагдаж 2020 оны 01 дүгээр сарын байдлаар суурь бүтэц эзэмшигч 3, тээвэрлэгч 3, суурь бүтэц барих, угсрах, засварлах эрх бүхий 75, албар замын тоо 481, салбар зам эзэмшигчийн тоо 169, төмөр замын тээвэр зуучийн үйлчилгээ эрхлэгч 201 зэрэг аж ахуйн нэгж тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцон, төмөр замын дэд бүтцийг эзэмшиж байна. 2019 онд 169 иргэн, хуулийн этгээдэд дагнасан хэрэглээний 481 замд гэрчилгээ олгосон

Аравдугаар хүснэгт  
**Хуулийн төслийн 40, 42, 52, 54 дүгээр зүйлийг үзэлэх**

Нэгдсэн зурмагаар зорчигч, ачааг төмөр замаар тээвэрлэх зорилгын хүрээнд хуулийн төслийн 40, 42, 52, 54 дүгээр зүйлд дүн шинжилгээ хийсэн байдал.


### **3.2.3 Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх**

Хуулийн төслийн 42 дугаар зүйлд Зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэлтийг гэрээний үндсэн дээр зорчигч болон ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хамтран оролцож, зорчигч тасалбарын үнийг төлөх, тээвэрлэгч нь зорчигч, ачаа, ачаан тээшийг тогтоосон газарт нь хүргэх үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан нь төмөр замын тээвэрлэлтийн гэрээний үндсэн дээр төмөр замын байгууллага болон зорчигч, ачаа илгээгч, ачаа хүлээн авагч хоорондын харилцааг зохицуулахаар хуульчилсан.

Хуулийн төслийн 45 дугаар зүйлд тээвэрлэлтийн явцад хүлээх зорчигчийн эрх үүргийг тусгасан нь нэгдсэн зурмагаар зорчигч тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв нь чиг үүргийнхээ дагуу суурь бүтэц эзэмшигч нарын хөдөлгөөний нэгдсэн зурмагийг зуны болон өвлийн хувиарын дагуу жилд 2 удаа батлан мөрдүүлж байна. Төмөр замын тээврийн нэгдсэн зурмагийг 2015 оноос эхлэн 8 удаа баталж, ачаа, зорчигч, тусгай болон транзит, экспорт, импорт, реэksportын тасралтгүй тээвэрлэлтийг гүйцэтгэсэн байна.

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дагаад Төмөр замын тээврийн дэд бүтцийг ашиглаж, тээвэрлэлтийн эрэлт хэрэгцээг хангахад тээврийн үндсэн үзүүлэлтийн өсөлтийг дараах байдлаар үзүүлэв.

### ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН 1990-2019 ОНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД




Хуулийн төсөл батлагдснаар төмөр замын сүлжээ нь олон улсын болон хил орчмын бүс нутгийн хамтын ажиллагаа хөгжиж, төмөр замаар ачаа, зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэлт өсөн нэмэгдэж, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасган, ирээдүйн тогтвортой хөгжлийг хангах боломж бүрдэнэ.

Хуулийн төслийн 40, 42, 52, 54 дүгээр зүйл заасан зохицуулалт нь төмөр замын нэвтрүүлэх чадварыг дээшлүүлж, уул уурхайн бүтээгдэхүүн, дамжин өнгөрүүлэх ачаа тээвэр болон экспорт, импортын ачаа эргэлтийг үр дүнтэй хангах, тээвэрлэлтийн оновчтой зохион байгуулалтыг бий болгон төмөр замын тээврийн дотоодын нэгдсэн сүлжээтэй өргөжүүлэх эрх зүй орчныг бүрдүүлж, төмөр замын тээврийн салбарын менежментийг боловсронгуй болж, техник, технологийн шинэчлэлт хийгдэнэ. Мөн ашигт малтмалын томоохон ордуудтай төмөр замаар холбогдсон аж үйлдвэрийн цогцолбор байгуулах, ашигт малтмалыг боловсруулж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, эдийн засгийн эргэлтийг хангах, экспортыг дэмжих замаар дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

Арваннэгдүгээр хүснэгт

#### **Төмөр замын тээврийг 2030 он хүртэл дээшлүүлэх боломжит хувилбар, үзүүлэлт**

Үзүүлэлтүүд	2010 он	2011 он	2012 он	2013 он	2030 оны төлөвлөлт		
					1-р хувилбар	2-р хувилбар	3-р хувилбар
Дотоодын тээвэр	8.3	8.6	9.9	10.7	17	17	21.4
Экспорт	4.6	6	6.6	6.1	11.8	23.8	39.1
Импорт	1.6	2	2.4	2.5	2.7	3.2	3.2
Транзит	2.3	1.9	1.5	1.7	3.1	4.2	10
Бүгд	16.8	18.5	20.4	21	34.6	48.2	73.7



**1-р график.** Төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг сайжруулах нөхцөл

#### **Төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд боломж бололцоо байгаа эсэх**

Хуулийн төслийн 42 дугаар зүйлд Зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэлтийн талаар тусгаж, зорчигч болон тээвэрлэгч гэрээний үндсэн дээр тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хамтран оролцож, зорчигч тасалбарын үнийг төлөх, тээвэрлэгч нь зорчигч, ачаа, ачаан тээшийг тогтоосон газарт нь хүргэх үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Мөн хуулийн төсөлд “Дэд бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч нь зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэлтийн үйл ажиллагааг хэрэглэгчийн эрэлт,

хэрэгцээнд нийцүүлэн хүртээмжтэй, найдвартай байдлыг хангах, өөрийн дэд бүтцийн хүрээнд галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах” үүргийг тусгасан байна. Төмөр замын тээврийн салбарын зорчигч тээвэрлэлтийг дэд бүтэц эзэмшигч, “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн хувьцаат компани дангаараа зорчигч тээвэрлэлтийн үйл ажиллагааг гүйцэтгэж байна. Төмөр замын тээврийн тухай хууль батлагдснаас хойш тээвэрлэсэн зорчигчийн тоог дараах хүснэгтэд үзүүлэв.

Арванхоёр хүснэгт

### Төмөр замын зорчигч тээвэрлэлтийн 2007-2019 оны үзүүлэлт

Үзүүлэлт	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Зорчигчид, мян.хүн	4 482.4	4 358.8	3 118.3	3 516.3	3 832.1	4 000.0	3 759.7	3 305.8	2 794.7	2 645.5	2 630.3	2 565.89	2 325.89

Төмөр замын тээврийн салбарт 2007 оны байдлаар ганц суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч буюу “УБТЗ” ХНН байсан бол өдгөө өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүйгээр суурь бүтэц эзэмшигч 3, тээвэрлэгч 3 болж нэмэгдсэн, суурь бүтэц барих, угсрах эрх бүхий 34, дагнасан болон салбар зам, талбай эзэмшигч 297, төмөр замын тээвэр зуучийн үлчилгээ эрхлэгч 213, давхардсан тоогоор 549 хуулийн этгээдтөмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагааг эрхлэн оролцож байна.

Хуулийн төслийн 45 дугаар зүйлд тээвэрлэлтийн явцад хүлээх зорчигчийн эрх үүргийг тусгасан нь нэгдсэн зурмагаар зорчигч тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Зорчигч нь бүх төрлийн галт тэрэг, вагонд тасалбар худалдан авч, тасалбарын дагуу суудал авах, нийтийн хэв журмыг сахин биелүүлэх, тээвэрлэгчийн эд хөрөнгөнд ариг гамтай хандах, галын аюулгүй байдлыг хангах зарчмаар төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцож байна.

Хуулийн төслийн 49 дугаар зүйлд “Ачаа тээвэрлэлтийн гэрээнд заасны дагуу тээвэрлэгч нь хүлээн авсан ачааны бүрэн бүтэн байдлыг хангаж, тээвэрлэлтийн нөхцөлийг мөрдөх, хүрэх өртөөнд ачаа хүлээн авагчид хугацаанд нь хүргэх, ачаа илгээгч нь ачаа тээвэрлэлтийн хөлс төлөх, ачаа хүлээн авах үүрэг хүлээнэ” гэж тусгасан нь ачаа тээвэрлэлтийг гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Ачаа тээвэрлэлтийн гэрээнд заасны дагуу тээвэрлэгч нь хүлээн авсан ачааны бүрэн бүтэн байдлыг хангаж, тээвэрлэлтийн нөхцөлийг мөрдөх, хүрэх өртөөнд ачаа хүргэх үүрэг, ачаа тээвэрлэлтийн гэрээг нотлох баримт түүний иж бүрдэл, төлбөр хураамжийн талаарх зохицуулалтыг тусгасан байна.

Хуулийн төслийн 51 дүгээр зүйлд “Ачаа тээвэрлэлт зохион байгуулах гэрээний дагуу ачаа илгээгч нь ачааг тээвэрлэгчид хүлээлгэн өгөх, тээвэрлэгч нь ачааг хүлээж авах, хүргэх үүрэгтэй, мөн тээвэрлэгч болон ачаа илгээгч нь байнгын тогтмол тээвэрлэлт хийх зорилгоор тээвэрлэлтийг зохион байгуулах урт хугацааны гэрээ байгуулах”-аар тусгасан байна. Энэ нь тээврийн хэмжээ, хугацаа, тээвэрлэлтийн чанар, ачааг тээвэрлэлтэд бэлтгэх нөхцөл зэргийг бүрдүүлж, нэгдсэн зурмагаар тээвэрлэлтийг зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

## ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

### 4.1 Үнэлэлт, дүгнэлт:

Хүчин төгөлдөр мөрдөж байгаа Төмөр замын тээврийн тухай хууль нь 2007 оны 7 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан бөгөөд 8 бүлэг, 34 зүйл, 341 заалттай. төмөр замын тээврийн үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахаар хуульчлагдсан байна.

Энэхүү хууль нь 2007 оноос хойш өнөөг хүртэл мөрдөгдөх явцад Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 08 дугаар сарын 17-ны, 2015 оны 12 дугаар сарын 04-ний, 2017 оны 02 дугаар сарын 02-ны, 2017 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн хуулиар тус тус нийт 4 удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Эдгээр нэмэлт өөрчлөлтөөр 2 зүйл заалт нэмсэн, 8 зүйл заалтад нэмэлт өөрчлөлт оруулсан, 2 зүйл заалтыг өөрчлөн найруулж, 9 зүйл заалтыг өөрчлөн, 2 зүйл заалтыг хүчингүй болгосон байна

Зам, тээврийн хөгжлийн яамны 2018 оны 197 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн дэд бүрэлдэхүүн Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолыг үндэслэн Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 11 бүлэг, 78 зүйлтэй, боловсруулж, хуулийн зорилтгыг “төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх, эзэмших, ашиглах, мөн нэгдсэн зурмагаар зорчигч, ачаа тээвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулах”-аар боловсруулсан.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг үнэлэхдээ шалгуур үзүүлэлт бүрээр дараахь байдаар үнэлж, дүгнэлээ.

### 4.2 Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн үр нөлөөг шалгуур үзүүлэлт бүрээр үнэлэхэд:

Зорилгод хүрэх шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн зорилго, үзэл баримтлалаас гурван төрлийн зорилгыг сонгон авч, эдгээр зорилгод хуулийн төслийн зүйл заалт хэрхэн нийцэж байгаад үнэлгээ хийсэн. Төмөр замын дэд бүтэц түүний өмчлөл, эзэмшил, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг, зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэлт, ачаа тээврийн төлөвлөлтийн эрх зүйн орчныг бүрдүүлэхийг зорьсон.

Төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх, эзэмших, ашиглах зорилгын хүрээнд 16, 18, 33, 42, 55 дугаар зүйлд хийгдсэн үнэлгээг харахад төмөр замын дэд бүтцийн төрлийг:

- төмөр замын дээд байгууламж, төмөр, дэр, чигжээс, суман шилжүүлэг болон бусад дээд байгууламж;
- нэг болон өөр төвшний огтлолцол, төмөр замын доод байгууламж (гүүр, хоолой, ус зайлзуулах, чиглүүлэх төхөөрөмж, тогтоох хана, хамгаалалт хана болон бусад), хашаа, хамгаалалтын байгууламж;
- ногоон байгууламж, төмөр замын өртөө, хэсэглэх газар, төмөр замын дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын байгууламж;
- сум дохионы харилцан хамаарлын болон диспетчерийн удирдлага зохицуулалтын систем зэрэг галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах байгууламжууд;
- төмөр замын харилцаа холбооны сүлжээ, агаарын болон газар доорх төмөр замын цахилгаан, ус хангамжийн шугам, контактны сүлжээ, трансформатор болон татах дэд станцууд;

- төмөр замын дэд бүтцийн байгууламжийн ашиглалт, засвар, арчлалтын зориулалттай барилга байгууламж;
- төмөр замын зурvas газар, зурvas газрын дагуух агаарын орон зайд гэж төрөлжүүлэн тусгажээ.

Нийтийн хэрэгцээний төмөр замын дэд бүтэц төрийн өмчид байх, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд эзэмшиж, нийтийн бус хэрэгцээний төмөр замын дэд бүтэц төрийн болон хувийн өмчийн аль ч хэлбэрийн байж болохоор тусгаж өмчлөгч, эзэмшигчийн эрхийг тогтоожээ. Мөн Төмөр замын дэд бүтцийг концессын барих-ашиглах-шилжүүлэх төрлөөр барьж байгуулсан бол уг гэрээний хугацаанд концесс эзэмшигч нь тухайн дэд бүтцийн эзэмшигч байхаар зохицуулсан байна.

Нэгдсэн зурмагаар зорчигч, ачаа тээвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулах зорилтын хүрээнд зорчигч, тээш, ачаан тээш, тээвэрлэлтийг гэрээний үндсэн дээр үйлчилгээ үзүүлэх талаар тусгаж, зорчигч, тээвэрлэгчийн эрх үүргийг тодорхойлсон байдал нь хуулийн зорилготой бүрэн нийцсэн гэж үзэж байна.

Гэвч, хуулийн төсөлд Төмөр замын тээврийн зориулалттай газар, тээвэрлэлтийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, гэрчилгээжүүлэлт, төмөр замын ачаа, зорчигч болон тусгай тээвэрлэлт, тус салбар дахь эдийн засаг санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалт, төмөр замын тээврийн аюулгүй байдал, салбарын ажилтны хөдөлмөрийн харилцааны онцлог зохицуулалт, салбарын бусад үйл ажиллагааг зохицуулахаар тусгасан байгаа нь хуулийн зорилгыг бүрэн гүйцэт тодорхойлж чадаагүй гэж дүгнэв.

#### ***Практикт хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:***

**Үг хуулийн төслийн хүрээнд сонгон авсан** Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, **Төмөр замын тээврийн нэгдсэн удирдлага, зохицуулалтын асуудал хариуцсан байгууллага**, түүний чиг үүрэг, бүрэн эрх, Төмөр замын дэд бүтцийн үйлчилгээ, Төмөр замын дэд бүтэц эзэмшигчийн эрх, үүргийн талаарх зүйл заалтууд нь практикт хэрэгжих боломж байгаа эсэхийг судлаад дараах дүгнэлтийг хийлээ. Үүнд:

- Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар тухай хуулийг хэрэгжүүлэх байгууллага, хүн, хуулийн этгээдийн талаарх зохицуулалт хангалттай тусгасан.
- Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нийтийн хэрэгцээний төмөр замын дэд бүтэц төрийн өмчид байх, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд эзэмшиж болохоор тусгаж, хуулийн үйлчлэлд хамаарах субъектыг тодорхойлж, практикт хэрэгжих боломжийг хангасан гэж үзлээ.

#### ***Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд:***

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь үнэлэхийг зорьж, хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултыг тодруулж, хуулийн төслийн дотоод болон бусад хууль тогтоомжтой хэрхэн уялдаж байгаа талаар үнэлэлт дүгнэлт өгөхийг зорьсон.

Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлалын дагуу тодруулах шаардлагатай байх 14 төрлийн асуултаас Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь **асуулгын хариултыг бүрэн хангасан, уялдаа холбоотой болсон байна** гэж дүгнэлээ.

Хуулийн төсөлд хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан, төрийн байгууллагын чиг үүргийг давхацуулалт байхгүй, жендерийн эрх тэгш байдлыг хангасан,

шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн зохицуулалт хийгдээгүй, авилга хүнд суртал бий болгоход чиглэсэн заалт тусгаагүй гэж дүгнэлээ.

I. Давхардал	II. Зөрчил	III. Хийдэл
<p>1.1 Хуулийн төсөлд байгаа зохицуулалтын бичвэрийг бусад хуульд давтан хуулбарлан хуульчилсан эсэх;</p> <p>1.2 Хуулийн төсөлд байгаа зохицуулалтыг бусад хуульд агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх;</p> <p>1.3 төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг хуульд давхардуулан хуульчилсан эсэх;</p> <p>1.4 Хуулийн төсөлд тодорхой зохицуулалтыг дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний давхардал, зөрчил, хийдлийг арилгахад чиглэгдсэн эсэх.</p>	<p>2.1 Хуулийн төслийн тухайн зохицуулалт нь хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх, нэр томъёог бусад хуулийн нэр томъёотой зөрчилдөж байгаа эсэх;</p> <p>2.2 Хуулийн төсөлд тодорхой асуудлыг гагцхүү тухайн хуулиар зохицуулахаар заасан боловч уг асуудлаар Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, бусад хуульд өөрөөр заасан эсэх, ишлэл, зохицуулалт нь холбогдох хуультай нийцэж байгаа эсэх;</p> <p>2.3 Хуулийн төсөлд өмчлөх эрхийг хязгаарлахад чиглэгдсэн эрх зүйн акт гаргах эрхийг бусад этгээдэд хуулиар олгосон эсэх;</p> <p>2.4 Хуулийн төслийн тодорхой зохицуулалтыг дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний зөрчлийг арилгахад чиглэгдсэн эсэх.</p>	<p>3.1 Хуулийн төсөлд тодорхой харилцааг нарийвчлан хуулиар зохицуулахаар заасан бол уг нарийвчилсан зохицуулалт бүхий хууль батлагдсан эсэх, нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг төрийн бусад байгууллагад шилжүүлсэн бол уг нарийвчилсан зохицуулалт батлагдсан эсэх;</p> <p>3.2 Хуулийн төсөлд заасан процессын шинжтэй зохицуулалт нь ойлгомжтой, тасралтгүй үргэлжлэх боломжтой байдлаар томъёолсон эсэх, тодорхой эрх, үүргийг хэрэгжүүлэх субъект нь тодорхой эсэх тодорхойлох;</p> <p>3.3 Хуулийн төсөлд заасан хориглосон зохицуулалт нь түүнийг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан тодорхой зохицуулалтыг дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний хийдлийг арилгахад чиглэгдсэн эсэх;</p> <p>3.4 Хуульд байх шаардлагатай зохицуулалт тусгагдсан эсэх.</p>

2.5 Хуулийн төслийн татварынхаас бусад хуульд тогтоомжид албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;

2.6 Хуулийн төсөлд тусгай зөвшөөрөл олгохоор заасан нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд туссан эсэх;

## **4.2. ЗӨВЛӨМЖ**

Төмөр замын тээврийн тухай хуулийн төслийн үр нөлөөг тооцох ажиллагааны үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- 1.Хуулийн төслийн зорилгыг хуулийн төслийн агуулгатай нийцүүлж дахин боловсруулах;
- 2.Хуулийн төслийн зорилгыг Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн батлагдсан үзэл баримтлалд тусгасан хуулийн зорилготой уялдуулах;
- 3.Хуулийн төслийн агуулгатай нийцүүлэн хуулийн төслийн нэр томьёог дахин боловсруулах;
- 4.Хуулийн төслийг агуулгыг анхаарч, зүйл хэсэг, заалтын доторх агуулга хороондоо зөрүүтэй байгааг залруулах. Тухайлбал: хуулийн төслийн 55 дугаар зүйл “Ачаа тээврийн төлөвлөлт” нэртэй боловч дотоод хэсгийн агуулга нь ачаа тээвэрлэлтийн төлөвлөлт бус, ачаа тээвэрлэлтийн гэрээний зохицуулалт байгааг анхаарах;
- 5.Хуулийн төслийн бичвэрийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйл “Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага”-тай нийцүүлэх;
- 6.Хуулийн төслийн бусад хуультай давхацсан заалтыг ишлэл хийж оруулах;
- 7.Хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний актын нэрийг тусгаж, батлах эрх бүхий этгээдийг тодорхой тусгах ;
- 8.Хуулийн төслөөс журамласан шинжтэй, нэг удаагийн үйлдэлтэй холбоотой заалтуудыг хасах
9. Хуулийн төслөөс хариуцлага хүлээлгэхтэй холбоотой зохицуулалтыг Зөрчлийн тухай хуульд тусгах;
10. Хуулийн төслийн утга найруулга, зүйл заалтын хоорондын уялдаа холбоог анхаарч залруулах талааар арга хэмжээ авах. Тухайлбал хуулийн төслийн Тавдугаар бүлэг Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг гэсэн ганц зүйлтэй байх гэх мэт;
- 11.Хуулийн төслийг дагалдаж гарах бусад хуульд орох нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах;
12. Санал авах, хэлэлцүүлэг явуулах явцад илрүүлсэн санал, хэлэлцүүлэгт оролцогчдоос хуулийн төслийг ойлгомтой болгох талааар гаргасан саналыг харгалзан үзэж, боломжит зохицуулалтыг томьёолж тусгах.

## ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг үнэлэхдээ Хууль тогтоомж, эрх зүйн акт, онолын ном, сурх бичиг, холбогдох вэб сайтуудын мэдээллийг ашигласан болно.

### Нэг. Хууль тогтоомж, олон улсын гэрээ, бусад эрх зүйн акт

#### 1.1 Эрх зүйн баримт бичиг

- Монгол Улсын Үндэс хууль 1992 он;
- Монгол Улсын Иргэний хууль 2002 он (35 дугаар бүлэг, 380-398 дугаар зүйл);
- Төмөр замын тээврийн тухай хууль 2007 он;
- Авто тээврийн тухай хууль 1999 он;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль 2015 он;
- Захиргааны ерөнхий хууль 2015 он;
- Хууль тогтоомжийн тухай хууль 2016 он;
- Авто замын тухай хууль 2017 он;
- Наушкаас Улаанбаатар хүртэл төмөр замыг байгуулж ашиглахын тулд Монгол Зөвлөлтийн хувьцаат нийгэмлэг байгуулах БНМАУ-ын Засгийн газар, ЗХУ-ын засгийн газар хоорондын хэлэлцээр 1948 он;
- Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр 1956 он;
- Монгол, Орос, Хятадын төмөр замын харилцааны хэлэлцээр 19 он;
- Төмөр замын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНСВУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр 2004 он;
- Төмөр замын салбар дахь харилцааны тухай Монгол Улсын болон Украян улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр 1995 он;
- Төмөр замын салбар дахь харилцааны тухай Монгол Улсын болон ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр 1996 он;
- Төмөр замын салбар дахь харилцааны тухай Монгол Улсын болон Турк улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр 2001 он;
- Төмөр замын салбар дахь харилцааны тухай Монгол Улсын болон Беларусь улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр 2003 он;
- Олон Улсын төмөр замын ачаа харилцааны хэлэлцээр 1951 он;
- Олон Улсын төмөр замын зорчигч харилцааны хэлэлцээр 1956 он;
- Монгол Улс, Хятад улсын нутаг дэвсгэрээр далайд гарах болон буцах, дамжин өнгөрөх тээвэр хийх тухай БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын засгийн газар хоорондын хэлэлцээр 1992 он;
- Монгол Улс, ОХУ-ын нутгаар дамжин тээвэр хийж, далайд гарах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын засгийн газар хоорондын хэлэлцээр 1992 он;
- Дамжин өнгөрөх журмын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр 1992 он;
- Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”;
- Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “ Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”;
- Улсын Их Хурлын 2017 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “2018 онд Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл”;

#### БОЛОВСРУУЛСАН:

Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг  
зохицуулах газрын ахлах мэргэжилтэн  
T.Мөнхцэцэг



## **1.2 Төмөр замын тээврийн салбарт мөрдөгдөж буй Үндэсний стандарт:**

### **Төмөр замын тээврийн салбарт мөрдөж буй үндсэний стандарт**

Д/д	Стандартын ангилал: 045:	MN S	MNS EN	MNS ГОС Т	MNS TB	Toо	Хууд ас
1.	Төмөр замын тээврийн нийтлэг, үндсэн стандарт	4	9			13	1283
2.	Төмөр замын, замын аж ахуйн чиглэлээр батлагдсан стандарт	7	36	1	3	44	2180
3.	Төмөр замын дохиолол, холбоо чиглэлээр батлагдсан стандарт	8	2	---		10	371
4.	Төмөр замын ачаа тээврийн чиглэлээр батлагдсан стандарт	8	3	---		11	157
5.	Төмөр замын зорчигч тээврийн чиглэлээр батлагдсан стандарт	1				1	5
6.	Төмөр замын тээвэр зуучлал, чингэлэг тээврийн чиглэлээр батлагдсан стандарт	1				1	6
7.	Төмөр замын илчit тэрэгний чиглэлээр батлагдсан стандарт	5			1	6	131
8.	Төмөр замын ачааны вагоны чиглэлээр батлагдсан стандарт	8	38	1		40	1148
9.	Төмөр замын зорчигчийн вагоны чиглэлээр батлагдсан стандарт	6	4			10	186
10.	Бүртгүүлэн хэрэглэж байгаа стандарт-MNSTB					1	386
<b>Нийт</b>		<b>44</b>	<b>88</b>	<b>2</b>	<b>4</b>	<b>148</b>	<b>6414</b>

## **1.3 Статистик мэдээ, судалгааны тайлан, ном, сурх бичиг, өгүүлэлүүд:**

- Шүүхийн ерөнхий зөвлөл 2007-2017 онуудад төмөр замын тээврийн хуультай холбоотой асуудлаар иргэн болон эрүүгийн хэргийг шүүхээр шийвэрлэсэн статистик судалгаа;
- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх хүний эрхийн үндэсний комиссын 10 дахь илтгэл 2011 он 3 дугаар бүлэг;
- Монгол Улсын Их Хурлын даргын 2013 оны 119 дүгээр захирамжаар байгуулагдсан “Монгол Улсын газар зүйн байрлалын давуу талыг ашиглан төмөр зам, авто зам, авто тээвэр, агаарын тээврийн дамжин өнгөрөх зорчигч, ачаа тээвэрлэлийг нэмэгдүүлэх, нэгдсэн тээврийн ложистикийн сүлжээг бий болгох, нефть, хийн хоолой, холбооны болон цахилгаан дамжуулах шугамын талаар нэгдсэн бодлого боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгээс зохион байгуулсан “Монголын төмөр замын хөгжлийн асуудлууд” эрдэм шинжилгээний бага хурал, “Төмөр замын тээвэр ложистикийн өнөөгийн байдал, цаашдын хөгжил” онол, практикийн бага хурал, “Евро-Азийн тээвэр болон бус нутгийн оролцоо” олон улсын бага хурлын илтгэлийн хураангуй, “Дамжин өнгөрөх тээвэр-хөгжлийн гарц” илтгэл 2013 он.
- “Хөгжлийн үр дүнд хүргэх удирдлага: Төмөр замын суурь бүтцийн тариф-Монгол Улсын төмөр замын салбарт хувийн хэвшлийн төлөвшлийг дэмжих нь” судалгааны тайлан. Азийн хөгжлийн банк 2014 он.

- Зам, тээврийн хөгжлийн яам, Шинжлэх ухааны академи хамтран зохион байгуулсан “Төмөр замын тээврийн эрх зүйн орчин, хөгжлийн асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүд, хурлаас гарсан зөвлөмж.

БОЛОВСРУУЛСАН:

*Төмөр зам, далайн тээврийн бодлогын  
хэрэгжилтийг зохицуулах газрын  
ахлах мэргэжилтэн  
Т.Мөнхцэцэг*

*Төрийн захиргааны удирдлагын газрын  
Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн  
С.Мяндасмаа*